



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахым хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.АМАРТҮВШИН ТАНАА

2022. 03. 29

№

1462

Төрийн

—ны №

—т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 59.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гүн өрмийн худгийн цооног гаргах” ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийж шууд худалдан авах гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн.
2. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгч, төсөл хэрэгжүүлэгч 10 иргэн 24.4 сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 8.6, 8.7.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8, Төсвийн тухай хуулийн 16.5.2, Иргэний хуулийн 222.4, 222.5, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11-дэх заалтуудтай нийцэхгүй, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 189.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 5,448.8 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу

8012020282

бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргын 2022 оны Б/333 дугаар бүхий үндэслэлгүй захирамжаар төсвийн шууд болон ерөнхийлөн захирагчид балансын урамшуулал олгосон зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байв. Аймгийн Засаг даргаас хүргүүлсэн чиглэлийн дагуу үндсэн чиг үүрэгт хамааралгүй, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан 20.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчил нь удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 зорилт, 125 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 113 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 91.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

Дунговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой зөрчил										
Дэрэн сумын ИТХ	-	-								
Дэрэн сумын ЗДТГ	1	-	-	-	1	-				
Дэрэн сумын СХС	-	-								
Дэрэн сумын ОНХС	-	-								
Дэрэн сумын БХС	-	-								
Дэрэн сумын МХС	-	-								
Дэрэн сумын ОННТ	-	-								
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дэрэн сумын ИТХ	-	-								
Дэрэн сумын ЗДТГ	2	21,666.3	1	1,666.3	1	20,000.0				
Дэрэн сумын СХС	-	-								
Дэрэн сумын ОНХС	1	-	-	-	1	-				
Дэрэн сумын БХС	-	-								
Дэрэн сумын МХС	-	-								
Дэрэн сумын ОННТ	1	46,156.4					1	46,156.4		
Дүн	4	67,822.7	1	1,666.3	2	20,000.0	1	46,156.4	-	-
Нийт дүн	5	67,822.7	1	1,666.3	3	20,000.0	1	46,156.4	-	-

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
							Заруулсан		Заруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дэрэн сумын ИТХ														
Дэрэн сумын ЗДПГ	5	16,893.7					5	16,893.7	5	16,893.7				
Дэрэн сумын СХС	1	631.0	1	631.0					1	631.0				
Дэрэн сумын ОНХС	2	321,707.1					2	321,707.1	2	321,707.1				
Дэрэн сумын БХС	2	5,442.0					2	5,442.0	2	5,442.0				
Дэрэн сумын МХС	1	6,250.0	1	6,250.0					1	6,250.0				
Дэрэн сумын ОННТ														
Дүн	11	350,923.8	2	6,881.0			9	344,042.8	11	350,923.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаарлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэрэн сумын ИТХ												
Дэрэн сумын ЗДПГ	6	8,283.8	-	-	4	8,114.2	2	169.6				
Дэрэн сумын СХС	1	24,384.8	1	24,384.8								
Дэрэн сумын ОНХС	2	67,400.0	1	8,000.0	1	59,400.0						
Дэрэн сумын БХС	2	10,172.10			1	143.8	1	10,028.3				
Дэрэн сумын МХС	2	18,676.20			1	625.6	1	18,050.6				
Дэрэн сумын ОННТ	-	-					0	-				
Дүн	13	128,916.90	2	32,384.80	7	68,283.6	4	28,248.5				

